

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/50/НА/-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Б.Должинжав

Утас: 89898557

цахим хаяг: Doljinjavb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл .....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
4. Аудитын илрүүлэлт .....	15
4.1 Залруулсан алдаа .....	15
4.2 Албан шаардлага.....	Error! Bookmark not defined.
4.3 Зөвлөмж .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	17

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нотлох ажил



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ  
Д.АХГУЛ ТАНАА

2022. 02.25 № 2/112  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### ХЯЗГААРЛАЛТАЙ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Ховд сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагын нярав эм, хүнс, түлш, бараа материалын тайлан гаргаагүй, шаардах хуудасгүй зарлагдсан, бараа материалын орлогын баримт няравын гарын үсгээр баталгаажуагүй, бараа материалын зарцуулалтад бүртгэлээр хяналт хэрэгжүүлээгүй, агуулахын үлдэгдлийн бүртгэл байхгүй, эд хөрөнгийн тооллогын бүртгэл хангалтгүй, тооцоо бодсон актгүй, И-баримтын бүрдэл хангалтгүй, төсвийн хөрөнгийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй, НДШ-ийн авлага зөрүүтэй тайлагнасан, авлагын дансанд он дамжсан, эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага бүртгэгдсэн, зардлыг хооронд нь гүйлгэн зарцуулснаар санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайланд буруу ангилан тайлагнасан зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

021020512

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	25,469,572.73	55,588,787.89
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	2,387,411.16
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	2,387,411.16
3121	Төгрөг	-	2,387,411.16
31211	Төрийн сангийн харилцах	-	2,387,411.16
33	АВЛАГА	1,197,787.90	29,785,406.90
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	437,739.90	1,423,558.90
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	28,063,500.00
335	Бусад авлага	760,048.00	298,348.00
3351	Байгууллагаас авах авлага	461,700.00	-
3352	Хувь хүмүүсээс авах авлага	298,348.00	298,348.00
35	БАРАА МАТЕРИАЛ	24,271,784.83	23,415,969.83
351	Түүхий эд материал	13,288,657.00	7,968,187.00
35110	Тусгай зориулалттай материал	-	2,619,206.00
35130	Эм боох материал	13,288,657.00	5,348,981.00
354	Хангамжийн материал	10,983,127.83	15,447,782.83
35410	Бичиг хэргийн материал	479,000.00	767,000.00
35420	Аж ахуйн материал	5,733,327.93	6,326,452.93
35440	Түлш, шатах тослох материал	950,000.00	2,400,000.00
35460	Хүнсний материал	1,233,299.90	794,129.90
35470	Бусад хангамжийн материал	2,587,500.00	5,160,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	328,797,872.64	316,690,847.82
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	328,797,872.64	316,690,847.82
392	Биет хөрөнгө	316,309,887.18	304,259,987.40
39201	Барилга, байгууламж, орон сууц	298,000,440.62	298,000,440.62
39202	Хуримтлагдсан элэгдэл	(13,559,229.32)	(25,596,328.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,220,222.00	36,860,222.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(28,233,096.10)	(30,989,818.18)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	75,394,416.00	85,956,223.56
39206	Хуримтлагдсан элэгдэл	(61,318,552.92)	(64,692,102.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,459,640.00	20,445,140.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,653,953.10)	(15,723,789.74)
393	Биет бус хөрөнгө	12,487,985.46	12,430,860.42
39301	Програм хангамж	982,000.00	982,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(592,614.54)	(649,739.58)
39303	Бусад биет бус хөрөнгө	12,098,600.00	12,098,600.00
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>354,267,445.37</b>	<b>372,279,635.71</b>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	5,456,427.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	5,456,427.00
413	Өглөг	-	5,456,427.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	139,050.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	5,302,377.00
4136	Бусад өглөг	-	15,000.00

41361	Байгууллагад төлөх өглөг	-	15,000.00
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	354,267,445.37	366,823,208.71
51	Засгийн газрын хувь оролцоо	354,267,445.37	366,823,208.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	160,773,037.00	160,773,037.00
51101	Өмч: - төрийн	160,773,037.00	160,773,037.00
512	Хуримтлагдсан үр дүн	71,175,526.93	83,731,290.27
51210	Өмнөх үеийн үр дүн	71,175,526.93	71,175,526.93
51220	Тайлант үеийн үр дүн	-	12,555,763.34
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	122,318,881.44	122,318,881.44
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	354,267,445.37	372,279,635.71

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			Төгрөгөөр
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	614,390,302.00	602,857,616.56
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	187,153,452.00	13,537,807.56
120	Нийтлэг татварын бус орлого	187,153,452.00	9,791,307.56
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	187,153,452.00	9,791,307.56
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	187,153,452.00	9,791,307.56
122	Тусламжийн орлого	-	3,746,500.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	3,746,500.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	427,236,850.00	589,319,809.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	367,155,300.00	394,912,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	367,155,300.00	394,912,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,998,300.00	150,178,569.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,998,300.00	150,178,569.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	19,147,000.00	14,147,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,147,000.00	14,147,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	5,000,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	35,936,250.00	30,081,340.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	35,936,250.00	30,081,340.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	429,638,252.03	590,301,853.22
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	429,638,252.03	590,301,853.22
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	427,287,327.03	557,811,853.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	299,296,878.00	356,679,509.64
210101	Үндсэн цалин	210,053,820.00	217,715,774.64
210102	Нэмэгдэл	65,435,028.00	98,932,446.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,241,000.00	5,214,557.00
210104	Урамшуулал	18,567,030.00	34,816,732.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,412,109.77	48,470,093.00
210201	Тэтгэврийн даатгал	25,440,234.65	34,306,094.90
210202	Тэтгэмжийн даатгал	2,992,968.78	3,540,999.44
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,394,375.02	2,832,799.56
210204	Ажилгүйдлийн даатгал	598,593.76	708,200.22
210205	Эрүүл мэндийн даатгал	5,985,937.56	7,081,998.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11,930,600.00	16,251,400.00
210301	Гэрэл, цахилгаан	1,495,600.00	2,123,400.00
210302	Түлш, халаалт	10,370,000.00	14,128,000.00
210303	Цэвэр, бохир ус	65,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	21,198,110.00	23,139,170.00
210401	Бичиг хэрэг	3,372,460.00	2,060,900.00
210402	Тээвэр, шатахуун	11,856,900.00	17,029,370.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,136,900.00	2,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,664,750.00	1,921,900.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,167,100.00	127,000.00
2105	Нормативт зардал	27,188,040.00	83,137,693.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,552,961.00	74,864,603.20
210502	Хоол, хүнс	4,639,579.00	7,580,590.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	995,500.00	692,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,636,000.00	1,293,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	262,500.00	-
210604	Урсгал засвар	1,373,500.00	1,293,500.00
2107	Томилолт, зочны зардал	580,000.00	204,000.00
210702	Дотоод албан томилолт	580,000.00	204,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,866,220.82	809,055.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,240,770.82	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	250,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	114,450.00	242,955.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	25,000.00
210807	Газрын төлбөр	-	30,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	281,000.00	181,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,179,368.44	27,827,432.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,304,240.00	3,279,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,875,128.44	24,548,332.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,350,925.00	32,490,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	32,490,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	32,490,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,850,925.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,850,925.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	184,752,049.97	12,555,763.34
5	<b>НИЙТ ҮР ДҮН</b>	<b>184,752,049.97</b>	<b>12,555,763.34</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	160,773,037.00	122,318,881.44	(113,576,523.04)	169,515,395.40
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	160,773,037.00	122,318,881.44	(113,576,523.04)	169,515,395.40
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	184,752,049.97	184,752,049.97
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	160,773,037.00	122,318,881.44	71,175,526.93	354,267,445.37
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	160,773,037.00	122,318,881.44	71,175,526.93	354,267,445.37
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	160,773,037.00	122,318,881.44	71,175,526.93	354,267,445.37
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	12,555,763.34	12,555,763.34
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	160,773,037.00	122,318,881.44	83,731,290.27	366,823,208.71

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	427,236,850.00	561,718,009.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	427,236,850.00	561,718,009.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	367,155,300.00	394,912,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	367,155,300.00	394,912,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,998,300.00	122,576,769.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,998,300.00	122,576,769.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	19,147,000.00	14,147,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	14,147,000.00	14,147,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	5,000,000.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	35,936,250.00	30,081,340.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	35,936,250.00	30,081,340.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	427,236,850.00	559,330,597.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	427,236,850.00	559,330,597.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	424,424,225.00	528,930,597.84

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	280,547,000.00	355,300,666.84
210101	Үндсэн цалин	184,784,085.36	185,224,261.88
210102	Нэмэгдэл	70,937,032.89	139,673,904.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,864,000.00	6,048,000.00
210104	Урамшуулал	17,961,881.75	24,354,500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,873,900.00	53,279,376.00
210201	Тэтгэврийн даатгал	26,652,000.00	39,162,076.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,805,500.00	3,317,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,244,400.00	2,879,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	561,100.00	720,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,610,900.00	7,199,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,823,000.00	12,918,900.00
210301	Гэрэл, цахилгаан	2,123,400.00	2,123,400.00
210302	Түлш, халаалт	10,349,100.00	10,795,500.00
210303	Цэвэр, бохир ус	350,500.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	19,302,300.00	21,220,685.00
210401	Бичиг хэрэг	2,793,100.00	2,065,800.00
210402	Тээвэр, шатахуун	11,906,400.00	15,292,805.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,006,900.00	2,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,595,900.00	1,862,080.00
2105	Нормативт зардал	40,006,181.00	75,273,870.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,506,181.00	66,135,950.00
210502	Хоол, хүнс	6,000,000.00	7,137,920.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,500,000.00	2,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,171,100.00	4,760,425.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,006,600.00	3,532,325.00
210604	Урсгал засвар	1,164,500.00	1,228,100.00
2107	Томилолт, зочны зардал	580,000.00	204,000.00
210702	Дотоод албан томилолт	580,000.00	204,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,833,144.00	1,104,475.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,988,694.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	200,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	114,450.00	299,475.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	25,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,287,600.00	4,868,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,287,600.00	4,868,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,812,625.00	30,400,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	30,400,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	30,400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,312,625.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,312,625.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	2,387,411.16

	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	2,387,411.16
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,387,411.16

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

ЭЗА	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	446,870,200.00	436,753,828.84	(10,116,371.16)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	446,870,200.00	436,753,828.84	(10,116,371.16)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	446,670,200.00	436,553,828.84	(10,116,371.16)
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	331,403,400.00	317,429,228.84	(13,974,171.16)
210101	Үндсэн цалин	202,954,600.00	185,224,261.88	(17,730,338.12)
210102	Нэмэгдэл	98,046,300.00	101,802,466.96	3,756,166.96
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,048,000.00	6,048,000.00	-
210104	Урамшуулал	24,354,500.00	24,354,500.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,739,500.00	48,597,300.00	3,857,800.00
210201	Тэтгэврийн даатгал	31,483,400.00	34,480,000.00	2,996,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,314,000.00	3,317,900.00	3,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,651,200.00	2,879,800.00	228,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	662,800.00	720,000.00	57,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,628,100.00	7,199,600.00	571,500.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,918,900.00	12,918,900.00	-
210301	Гэрэл, цахилгаан	2,123,400.00	2,123,400.00	-
210302	Түлш, халаалт	10,349,100.00	10,795,500.00	446,400.00

210303	Цэвэр, бохир ус	446,400.00	-	(446,400.00)
2104	Хангамж, бараа материалын зардал	17,595,000.00	16,957,080.00	(637,920.00)
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,200,000.00	-
210402	Тээвэр, шатахуун	11,895,000.00	11,895,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,000,000.00	2,000,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.00	1,862,080.00	(637,920.00)
2105	Нормативт зардал	30,480,300.00	32,226,220.00	1,745,920.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,980,300.00	23,088,300.00	1,108,000.00
210502	Хоол, хүнс	6,500,000.00	7,137,920.00	637,920.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	2,000,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,228,100.00	2,360,425.00	132,325.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	1,132,325.00	132,325.00
210604	Урсгал засвар	1,228,100.00	1,228,100.00	-
2107	Томилолт, зочны зардал	1,200,000.00	92,000.00	(1,108,000.00)
210702	Дотоод албан томилолт	1,200,000.00	92,000.00	(1,108,000.00)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,105,000.00	1,104,475.00	(525.00)
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	200,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	299,475.00	(525.00)
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	80,000.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	25,000.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	500,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	4,868,200.00	(131,800.00)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	4,868,200.00	(131,800.00)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200,000.00	200,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	200,000.00	200,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	200,000.00	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>446,870,200.00</b>	<b>439,141,240.00</b>	<b>(7,728,960.00)</b>

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	394,912,900.00	394,912,900.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	394,912,900.00	394,912,900.00	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	14,147,000.00	14,147,000.00	-
132001	Орон нутгийн төсвөөс	14,147,000.00	14,147,000.00	-
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	37,810,300.00	30,081,340.00	(7,728,960.00)
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	37,810,300.00	30,081,340.00	(7,728,960.00)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		2,387,411.16	2,387,411.16
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	27.00	27.00	-
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00	-
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	-
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	4,998,300.00	122,576,769.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,998,300.00	122,576,769.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,536,600.00	92,376,769.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	40,212,476.00
210102	Нэмэгдэл		40,212,476.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	2,341,038.00
210201	Тэтгэврийн даатгал		2,341,038.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	4,263,605.00
210401	Бичиг хэрэг		865,800.00
210402	Тээвэр, шатахуун		3,397,805.00
2105	Нормативт зардал	4,536,600.00	43,047,650.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,536,600.00	43,047,650.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	2,400,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		2,400,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	112,000.00
210702	Дотоод албан томилолт		112,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	30,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	30,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		30,200,000.00

2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	461,700.00	-
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	461,700.00	
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	4,998,300.00	122,576,769.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,998,300.00	122,576,769.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,998,300.00	122,576,769.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд НББ, тайлагнал, дотоод хяналт, төсвийн хөрөнгийн үр ашиг, арвилан хэмнэлттэй холбоотой асуудлаар зөвлөмж өгсөн болно.

Аудитыг аудитор Б.Должинжав 2022 оны 02 дугаар сарын 18-нээс 02 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ховд сумын эрүүл мэндийн төв нь “Төр засгийн болон аймаг, сумын бодлогын хэрэгжилтийг шуурхай удирдлагаар хангах, үр дүнг шударгаар тооцох замаар төрийн үйлчилгээний бүтээмжийг нэмэгдүүлэх, иргэддээ чанартай үйлчилгээ үзүүлэх улмаар орон нутгийн хөгжлийг тэтгэх чадварлаг эмнэлгийн байгууллагыг төлөвшүүлнэ” гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажиллажээ.

Тухайн онд Эрүүл мэндийн газраас эмнэлгийн үйл ажиллагаа болон санхүүгийн үйл ажиллагаанд 2 удаа дотоод хяналтыг хэрэгжүүлэн зөвлөмж, чиглэл өгч ажилласан байна.

Тус байгууллагын нягтлан бодогч нь байгууллагын хэмжээнд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан ажиллаж байгаа хэдий ч удирдлагаар батлуулаагүй, тухайн баримт бичгийг боловсронгуй болгож шинэчлэн сайжруулах шаардлагатай байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд аудитын зорилго оршино.

Ховд сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар бүртгэж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлан гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, эрсдэлийн үнэлгээнээс хамаарч материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэлсэн учир материаллаг байдлын түвшинг хамгийн ихээр буюу 2 хувиар тогтоосон.

Материаллаг байдлын түвшинг 2021 оны батлагдсан төсөв 446.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 8.9 сая төгрөгөөр тооцож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар буюу 7.1 сая төгрөгөөр тогтоов.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Ховд сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18.0 сая төгрөгөөр өссөний материаллаг өөрчлөлт гарсан нь авлагын данстай холбоотой байна.

Тайлант оны эхэнд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байсан бол оны эцэст 2.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлага дансны оны эхний үлдэгдэл 1.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол оны эцэст 29.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж 28.7 сая төгрөгөөр өссөн байна. Эцсийн үлдэгдэл дэх 29.8 сая төгрөгийн авлагын 28.1 сая төгрөг нь эрүүл мэндийн даатгалын сангаас ковид-19 санхүүжилтийн авлага, 1.4 сая төгрөг нь оны эцэст НДШ-д илүү шилжүүлсэн авлага, 0.3 сая төгрөг нь он дамжин бүртгэгдсээр байгаа эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага байна.

Бараа материал данс оны эхэнд 24.3 сая төгрөг байсан бол оны эцэст 23.4 сая төгрөг болж 0,8 сая төгрөгөөр өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 116.8 сая төгрөгийн бараа материал худалдан авч, УИХ-ын гишүүнээс 3.7 сая төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй хүлээн авч, 121.4 сая төгрөгийн материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны оны эхний үлдэгдэл 447.1 сая төгрөг байсан ба тайлант онд төсвийн хөрөнгөөр 2.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, ТЭХ худалдан авч, Эрүүл мэндийн газар, сумын Засаг даргын Тамгын газар, хувь хүнээс нийт 9.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авч, 5.2 сая төгрөгийн хөрөнгө акталж данс бүртгэлээс хасаж, оны эцэст үндсэн хөрөнгийн данс 454.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Оны эхэнд өр төлбөргүй байсан бол оны эцэст 5.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй болж өссөн байна. Эцсийн үлдэгдэл дэх 5.4 сая төгрөгийн 4.7 сая төгрөг нь түлш халаалтын өглөг, 0.5 сая төгрөг нь тээвэр шатахууны өглөг, 0.1 сая төгрөг нь ХХОАТ-ын өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 354.3 сая төгрөг байсан ба оны эцэст 366.8 сая төгрөг болж тайлант онд 12.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр өмнөх оны үр дүнд залруулга хийгдээгүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Ховд сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны төсвийн нийт зардлыг анх 446.9 сая төгрөгөөр баталсан ба тодотголоор нийт дүнд өөрчлөлт ороогүй байна.

Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын шилжүүлгээс 394.9 сая, орон нутгийн төсвөөс 14.1 сая, эрүүл мэндийн даатгалын сангаас 37.8 сая нийт 446.9 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 394.9 сая, орон нутгийн төсвөөс 14.1 сая, эрүүл мэндийн даатгалын сангаас 30.0 сая нийт 439.1 сая төгрөгийн санхүүжилт авч батлагдсанаас 7.7 сая төгрөгийн санхүүжилт дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 436.7 сая төгрөг буюу 97.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 14.0 сая, хангамж, бараа материалын зардлыг 0.7 сая, томилолт, зочны зардлыг 1.1 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.1 сая төгрөгөөр тус тус хэмнэж, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 3.8 сая, нормативт зардлыг 1.7 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 0.1 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу төсвийн байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар эрүүл мэндийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Ковид-19-ын санхүүжилт 87.0 сая, Эрүүл мэндийн газраас 35.1 сая, нийт 122.1 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн дээрх эх үүсвэрийг холбогдох арга хэмжээнд зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын эдийн засгийн ангилал тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй дараах асуудал байна. Үүнд:

Нэмэлт санхүүжилтийн дансаар эрүүл мэндийн даатгалын сангаас авах 28.1 сая төгрөгийн авлага нь ковид-19-ын вакцинжуулалт, улаан бүсэд ажилласан ажилчдын илүү цагийн урамшууллын зардлын тооцоо байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд хагас жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, түүнчлэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зардлын мөнгөн гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээг мэдээлээгүй. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 1, 2 дугаар сар, 1, 2, 3 дугаар улирлыг мэдээлээгүй, тоо мэдээлэл үзүүлэлтийн дэд дүн, нийт дүнг тусгаагүй, хэтрэлт хэмнэлтийн тайлбаргүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 2.0 сая төгрөгийн төлбөрийн актыг бүрэн барагдуулсан ч зөвлөмжийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал байхгүй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 695.7 сая төгрөгийн 10 алдаа зөрчил илэрснээс 107.9 сая төгрөгийн 4 алдаа, зөрчлийг залруулж, 1.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1.1 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 585.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тайлант оны эцэст 0.5 сая төгрөгийн татаас санхүүжилтийн авлага илүү бүртгэсэн. Нэмэлт санхүүжилтийн дансан дахь авлагаар бүртгэсэн санхүүжилтийг санхүүгийн үр дүнгийн тайланд орлогоор давхар бүртгэсэн .
2. Санхүүгийн байдлын тайланд төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл 2.4 сая төгрөг дутуу тайлагнасан.
3. Санхүүгийн үр дүнгийн тайлан, үндсэн хөрөнгийн тодруулга тайланд үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 18.0 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн.
4. Нэмэлт санхүүжилтийн дансны тайлан дахь 87.0 сая төгрөгийн орлогын эх үүсвэрийг үндсэн дансны ЭМДС-ийн санхүүжилт ангиллаар буруу бүртгэн тайлагнасан.

**Шийдвэрлэсэн нь:** Аудитын явцад санхүүгийн тайланд нийт 107.9 сая төгрөгийн залруулга хийхийг шалгагдагч байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, шалгагдагч байгууллага тухайн бүртгэлийг залруулан 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 29 тоот албан бичгээр хариу ирүүлсэн.

### 4.2 Төлбөрийн акт

1. Цалингийн сангийн хэмнэлт 1.4 сая төгрөгийг оны эцэст НДШ-д илүү шилжүүлж авлагаар бүртгэсэн нь холбогдох хууль тогтоомжид нийцээгүй.

**Шийдвэрлэсэн:** Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй тул төлбөрийн акт тогтоов.

### 4.3 Албан шаардлага

1. Шилэн дансны цахим системд хагас жилийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, түүнчлэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зардлын мөнгөн гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээг мэдээлээгүй. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 1, 2 дугаар сар, 1, 2, 3 дугаар улирлыг мэдээлээгүй, тоо мэдээлэл үзүүлэлтийн дэд дүн, нийт дүнг тусгаагүй, хэтрэлт хэмнэлтийн тайлбаргүй байна.

Шийдвэрлэсэн: Шилэн дансны хухай хуулийн 4, 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-д тус тус нийцээгүй тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

2. Шүүхийн шийдвэрээр ажилтны цалин, нөхөн олговрыг байгууллагын төсвөөс барагдуулсан боловч буруу шийдвэр гаргасан хуулийн этгээдээр төсөвт учирсан 1.1 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлээгүй, авлагаар бүртгээгүй байна.

Шийдвэрлэсэн: Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ”, 103.2-д “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэсэн заалттай нийцүүлж, тухайн төлбөрийг барагдуулах албан шаардлага өгөв.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. **НББ, дотоод хяналттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Байгууллагын нярав эм, хүнс, түлш, бараа материалын тайлан гаргаагүй, тайлант онд 1671 нэр төрлийн бараа материал шаардах хуудасгүй зарлагдсан, бараа материалын орлогын баримт няравын гарын үсгээр баталгаажаагүй, бараа материалын зарцуулалт, түүвэрт бүртгэлээр хяналт хэрэгжүүлээгүй, агуулахын үлдэгдлийн бүртгэл байхгүй, эд хөрөнгийн тооллогын бүртгэл хангалтгүй, тооцоо бодсон актгүй, тооллогын хурлын тэмдэглэл байхгүй. Бараа, ажил үйлчилгээний төлбөрийг И-баримтын бүрдэлгүй гүйцэтгэсэн.

Өгсөн зөвлөмж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.1-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан нягтлан бодогчийн эрх, үүргийн хүрээнд нийцүүлэн дээрх зөрчлийг хойшид давтан гаргахгүй байх, санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулахад анхаарч ажиллах.

#### 2. **Төсвийн хөрөнгийн үр ашиг, арвилан хэмнэлттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тухайн онд төвлөрсөн халаалтын системд холбогдох төлөвтэй байсныг үл харгалзан 15 тн нүүрс их хэмжээгээр нөөцөлсөн, өр төлбөр үүсгэсэн нь төсвийн хөрөнгийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, гэсэн заалттай тус тус нийцүүлж төсвийн хөрөнгийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж ажиллах, мөн үлдэгдэл 15 тн нүүрсийг бэлтэн нийлүүлэгч компанид буцаан өгч, өр төлбөрийг барагдуулах ажлыг зохион байгуулах.

### 3. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** НДШ-ийн авлага балансад 1.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байхад НДШ-ийн тайлан тооцоогоор 2.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй буюу 0.6 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан, авлагын дансанд 0.3 сая төгрөгийн он дамжсан, эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага бүртгэгдсэн, зардлыг хооронд нь гүйлгэн зарцуулснаар санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайланд нийт 6.3 сая төгрөгийн цалин, НДШ, бараа үйлчилгээний бусад зардлуудыг буруу ангилан тайлагнасан.

**Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.1-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах үүрэгтэй”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан нягтлан бодогчийн эрх, үүргийн хүрээнд нийцүүлэн дээрх зөрчлийг арилгаж, хойшид давтан гаргахгүй байх, санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулахад анхаарч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ховд сумын ЭМТ	10	695.7	4	107.9	1	1.4	2	1.1	3	585.3

#### АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

#### ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

Б.ДОЛЖИНЖАВ

**3. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** НДШ-ийн авлага балансад 1.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байхад НДШ-ийн тайлан тооцоогоор 2.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй буюу 0.6 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан, авлагын дансанд 0.3 сая төгрөгийн он дамжсан, эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага бүртгэгдсэн, зардлыг хооронд нь гүйлгэн зарцуулснаар санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайланд нийт 6.3 сая төгрөгийн цалин, НДШ, бараа үйлчилгээний бусад зардлуудыг буруу ангилан тайлагнасан.

**Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.1-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах үүрэгтэй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан нягтлан бодогчийн эрх, үүргийн хүрээнд нийцүүлэн дээрх зөрчлийг арилгаж, хойшид давтан гаргахгүй байх, санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулахад анхаарч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ховд сумын ЭМТ	10	695.7	4	107.9	1	1.4	2	1.1	3	585.3

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Ж.БОЛДЕБАТАРАУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:  Б.ДОЛЖИНЖАВ



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 47/А2170428

Ховд

ХОА-2022/50/НА/СТА-ТШЗ

## ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ховд сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан баталгаажуулах аудитаар цалингийн сангийн хэмнэлт 1423558 төгрөгийг оны эцэст НДШ-д илүү шилжүүлж авлага үүсгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 1423558 /Нэг сая дөрвөн зуун хорин гурван мянга таван зуун тавин найман төгрөг /-ийг төрийн сангийн бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2022 оны 04 дүгээр сарын 15-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Ховд сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч Д.Ахгүл, нягтлан бодогч Х.Дүйсенбек нарт хариуцуулав.

## ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

АУДИТОР

Б.ДОЛЖИНЖАВ



1

<sup>1</sup> Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061

02:050149



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 16/А/217-0428

Ховд

ХОА-2022/50/НА-СТА-ТШЗ

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ховд сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд аудит хийхэд шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим системд санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, түүнчлэн аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, хагас жилийн санхүүгийн тайлан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зардлын мөнгөн гүйлгээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээг мэдээлээгүй. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 1, 2 дугаар сар, 1, 2, 3 дугаар улирлыг мэдээлээгүй, тоо мэдээлэл үзүүлэлтийн дэд дүн, нийт дүнг тусгаагүй, хэтрэлт хэмнэлтийн тайлбаргүй байна.

Энэ нь Шилэн дансны хухай хуулийн 4, 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-д тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ховд сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч Д.Ахгүл, нягтлан бодогч Х.Дүйсенбек нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

АУДИТОР

Б.ДОЛЖИНЖАВ



<sup>1</sup> Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061

• 071070066



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 17/А/217-0428  
ХОА-2022/50/НА-СТА-ТШЗ

Ховд

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ховд сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд аудит хийхэд шүүхийн шийдвэрээр ажилтны цалин, нөхөн олговрыг байгууллагын төсвөөс барагдуулсан боловч буруу шийдвэр гаргасан хуулийн этгээдээр төсөвт учирсан 1.1 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлээгүй, авлагаар бүртгээгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", 103.2-д "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэсэн заалттай тус тус нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Дээрх зөрчлийг арилгаж биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>2</sup> ирүүлэх.
- Цаашид алдаа, зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ховд сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч Д.Ахгүл, нягтлан бодогч Х.Дүйсенбек нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

АУДИТОР

Б.ДОЛЖИНЖАВ



<sup>1</sup> Монгол Улс, Ховд аймаг, Жаргалант сум, Цамбагарав баг, Засаг даргын Тамгын газрын байр, 3 давхар Утас: 70433061

021040046